

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“ХАНТЭНГЭРИЙН ДУУДЛАГА” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д. ДАШЧОЙНХОР

**БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ӨНДӨР ЭРЭГ-
II” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**
Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022159

БОЛОВСРУУЛСАН:
“ХАНТЭНГЭРИЙН ДУУДЛАГА” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Х.МӨРӨН



АГУУЛГА

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	3
1.1. Байгууллагын мэдээлэл	3
1.2. Төслийн танилцуулга мэдээлэл	3
1.2.1. Талбайн байршил.....	3
1.2.2. Ордын нөөц	4
1.3. Ил уурхайн ашиглалтын технологи, ажиллах горим.....	6
1.4. Ил уурхайн хүчин чадал, технологи.....	6
1.5. 2024 оны уулын ажлын төлөвлөгөө.....	7
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ	9
2.1. Байгаль орчны онцлог.....	9
2.2. Нийгэм эдийн засаг	9
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	10
3.1. Агаарын чанар	10
3.2. Хөрсөн бүрхэвч	10
3.3. Гадаргын болон газрын доорх ус.....	11
3.4. Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	12
3.5. Ургамлан нөмрөг	12
3.6. Амьтны аймаг	12
3.7. Нийгэм эдийн засаг	13
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	14
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	16
4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .	16
4.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	17
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	17
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
4.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	20
4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө.....	21
ДҮГНЭЛТ	22



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Талбайн байршлын зураг	3
Зураг 2. Уурхайн ам, ажилчдын байр	4
Зураг 3. Ордын нөөцийн дэвсгэр зураг	5
Зураг 4. 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний план зураг	8

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэг.....	4
Хүснэгт 2. Ордын геологийн нөөц	5
Хүснэгт 3. Ашиглалтын системийн элементүүд.....	6
Хүснэгт 4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	14

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ


1.1. Байгууллагын мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч “Хантэнгэрийн дуудлага” ХХК
Улсын бүртгэлийн дугаар 9011184085
Регистрийн дугаар 5287359
Хаяг Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 3 хэсэг, блоу скай, 44в, 14 тоот
Холбоо барих утас 8888-5657

1.2. Төслийн танилцуулга мэдээлэл

1.2.1. Талбайн байршил

“Өндөр-Эрэг 2” орд нь Улаанбаатар хотоос 240 км, Дархан-Уул аймгаас 200 км, Хөтлийн цементийн үйлдвэрээс 180 км, Булган аймгаас 130 км, Булган аймгийн Бүрэгхангай сумаас 77 км, “Шижир алт, Алтан дорнод” компаниудын Өгөөмөр тосгоноос 15 км зайд оршино.



ЗУРАГ 1. ТАЛБАЙН БАЙРШЛЫН ЗУРАГ



Зураг 2. Уурхайн ам, ажилчдын байр

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэг

№	Тэгш өнцгийн солбицол		Газарзүйн солбицол		Талбай, га
1	461864.6427	5361654.096	104° 29' 4.940" E	48° 24' 24.800" N	262.65
2	461720.9464	5361655.064	104° 28' 57.950" E	48° 24' 24.800" N	
3	461735.7444	5363816.071	104° 28' 57.960" E	48° 25' 34.790" N	
4	464018.1943	5363802.351	104° 30' 49.030" E	48° 25' 34.830" N	
5	464021.5024	5364323.229	104° 30' 49.030" E	48° 25' 51.700" N	
6	464534.9893	5364319.991	104° 31' 14.020" E	48° 25' 51.700" N	
7	464531.7285	5363799.113	104° 31' 14.020" E	48° 25' 34.830" N	
8	464367.1263	5363800.145	104° 31' 6.010" E	48° 25' 34.830" N	
9	464365.3787	5363522.261	104° 31' 6.010" E	48° 25' 25.830" N	
10	463769.617	5363526.039	104° 30' 37.020" E	48° 25' 25.830" N	
11	463767.6428	5363217.279	104° 30' 37.020" E	48° 25' 15.830" N	
12	463027.5758	5363222.06	104° 30' 1.010" E	48° 25' 15.830" N	
13	463026.3611	5363035.877	104° 30' 1.010" E	48° 25' 9.800" N	
14	462675.532	5363038.177	104° 29' 43.940" E	48° 25' 9.800" N	
15	462673.2951	5362698.542	104° 29' 43.940" E	48° 24' 58.800" N	
16	462447.2054	5362700.035	104° 29' 32.940" E	48° 24' 58.800" N	
17	462445.7734	5362483.903	104° 29' 32.940" E	48° 24' 51.800" N	
18	462260.5783	5362485.133	104° 29' 23.930" E	48° 24' 51.800" N	
19	462259.1393	5362269.002	104° 29' 23.930" E	48° 24' 44.800" N	
20	462115.4586	5362269.96	104° 29' 16.940" E	48° 24' 44.800" N	
21	462113.8078	5362022.953	104° 29' 16.940" E	48° 24' 36.800" N	
22	461949.3592	5362024.054	104° 29' 8.940" E	48° 24' 36.800" N	
23	461947.9086	5361807.923	104° 29' 8.940" E	48° 24' 29.800" N	
24	461865.6811	5361808.476	104° 29' 4.940" E	48° 24' 29.800" N	


1.2.2. Ордын нөөц

2020 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр тооцсон нөөцийн тооцооны үр дүнд ордын хэмжээнд нийт бодитой В зэрэглэлээр 839.2 мг/м^3 -ийн дундаж агуулгатай 161.25 кг химийн цэвэр алт, боломжтой С зэрэглэлээр 644.5 мг/м^3 -ийн дундаж агуулгатай 11.33 кг химийн цэвэр алт, нийт В+С зэрэглэлийн зэрэглэлийн 822.9 мг/м^3 -ийн дундаж агуулгатай 172.58 кг химийн цэвэр алтны нөөц тооцжээ.



Хүснэгт 2. Ордын геологийн нөөц

Блокын дугаар, Нөөцийн зэрэг	Блокын талбай	Хөрсний зузаан	Элсний зузаан	Хөрсний эзлэхүүн	Элсний эзлэхүүн	Дундаж агуулга	Металлын нөөц /Шлих/	Хими цэвэр
Х.нэгж	м ²	м	м	мян.м ³	мян.м ³	мг/м ³	кг	кг
В-1	21,264.5	60.7	1.9	1,291.2	39.3	729.0	28.68	26.14
В-2	34,145.6	59.6	1.7	2,034.7	57.4	813.0	46.62	42.50
В-3	38,717.3	54.6	1.6	2,115.1	60.4	877.0	52.95	48.27
В-4	37,013.7	49.1	1.5	1,816.3	53.7	906.0	48.64	44.34
С-1	8,929.4	59.6	2.2	532.5	19.3	644.0	12.43	11.33
Нийт В	131,141.1	55.3	1.6	7,257.3	210.8	839.2	176.89	161.25
Нийт С	8,929.4	59.6	2.2	532.5	19.3	644.5	12.43	11.33
Нийт В+С	140,070.5	55.6	1.6	7,789.9	230.1	822.9	189.32	172.58



ЗУРАГ 3. Ордын нөөцийн дэвсгэр зураг



1.3. Ил уурхайн ашиглалтын технологи, ажиллах горим

Ил уурхайн ашиглалтын технологи, ажиллах горим. Ашиглалтын системийн элементүүд. Экскаватор, автосамосвалын техникийн үзүүлэлтүүд болон ордын хөрсний чулуулгийн физик, механикийн шинж чанар, олборлолтын нөхцөл, ашигт давхарга, хөрсний зузаан зэргээс хамааруулан ашиглалтын системийн үндсэн хэмжигдэхүүнүүдийг аргачлалын дагуу тооцоолж доорхи хүснэгтэд үзүүлэв.

Доголын өндөр: Ашиглах техникүүдээс сонгосон экскаваторын угталтын гүн, бага гүний ордын хөрсний зузаан зэргээс хамааруулан хөрсний ажлын доголын өндрийг дунджаар $H_d=3.5$ м байхаар тооцов.

Доголын хажуугийн өнцөг: Доголын хажуугийн өнцөг нь чулуулгийн шинж чанарын нөхцлөөр ажлын доголд $\alpha_d=550$, ажлын бус доголд $\alpha_d=550$ байна. Энэхүү хэмжээ төсөл зохиомжид мөрдлөг болгодог нөхцөлтэй зөрчилдөхгүй ($f=1-2$, зөөлөндүү ба зөөлөн чулуулаг бол $\alpha_d=40$ 0 -550).

ХҮСНЭГТ 3. АШИГЛАЛТЫН СИСТЕМИЙН ЭЛЕМЕНТУУД

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоо, хэмжээ
1	Доголын өндөр	м	-7 -3.5 0.6-2.5
	– Хаалтын догол		
	– Хөрсний догол		
	– Элсний догол /давхаргын зузаанаар		
2	Доголын хажуугийн өнцөг	градус	-55 -55 -35-48
	– Ажлын догол		
	– Ажлын бус		
	– Ил уурхайн ерөнхий налуу		
3	Экскаваторын орлын өргөн	м	12
4	Аюулгүйн бермийн өргөн	м	2.5
5	Ажлын талбайн өргөн	м	36
6	Траншейн замын өргөн	м	12
7	Траншейн замын налуу	%	100

Ажиллах горим. Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, ордын ашиглалтын нөхцөл зэргээс хамааруулан жилд дулааны улирлын 6 сар буюу 180 хоногийн хугацаанд, өдөрт 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллуулахаар төлөвлөөд байна. Уурхайн үйл ажиллагаа нь улирлын чанартай тул уурхайн операторууд, туслах ажилчид болон ИТА-ыг улирлын чанартай ажиллуулахаар төсөлд тусгасан. 2024 онд 3-р сарын 1-нээс эхлэн бэлтгэл ажлууд болон үржил шимт хөрс хуулах ажлыг гүйцэтгэж, 4 сарын 1-ээс 10-р сарын 1 хүртэл ажиллахаар төлөвлөв. Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана.

1.4. Ил уурхайн хүчин чадал, технологи

Ил уурхайн хүчин чадал. 2024 онд 8771.13 мян.м³ хөрс олборлон 246.71 мян.м³ алттай элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана.

Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж. Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайг өөрт байгаа техник, тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан 2024 оны бүтээлийн тооцоог гүйцэтгэв.



Ил уурхайн үндсэн технологийн процесс нь өнгөн хөрсийг бульдозероор хуулж овоолгод байршуулах, хөрсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж гадаад болон дотоод овоолгод байршуулах, алттай элсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж баяжуулах үйлдвэрийн хажууд овоолгод байршуулах зэрэг байна.

1.5. 2024 оны уулын ажлын төлөвлөгөө

Уурхайн бэлтгэл ажил 2024 оны 03-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэнэ.

Тухайн жилд ашиглах блокуудын шимт хөрсийг ялган бульдозероор түрж блокын хилийн гадна гадаад овоолгод байршуулж үндсэн хөрсийг экскаватор, автосамосвал ашиглан 2023 онд үүсгэсэн орон зайд дотоод овоолго хийхээр төлөвлөв.

Орд нь харьцангуй гүний орд тул ашиглалтын ажилтай зэрэгцэн олборлолтын хажуугаар техникийн нөхөн сэргээлтийг хийх бөгөөд олборлосон орон зайд дотоод овоолго хийх хэлбэрээр гүйцэтгэх боломжтой байна.

2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр В-1 блокийн үлдэгдэл хэсгийг, В-2, В-3, В-4, С-1 блокуудыг бүхэлд нь олборлохоор төлөвлөсөн. 2024 онд дээрх блокуудаас нийт 8771.13 мян.м³ хөрс хуулж, дунджаар 610 мг/м³ агуулгатай 246.71 мян.м³ элс олборлон баяжуулж 124.43 кг алт /химийн цэврээр/ олборлохоор байна.



2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Байгаль орчны онцлог

Булган аймгийн зүүн урд хэсэгт: Улаанбаатар хотоос 265 км, Аймгийн төвөөс 86 км зайд байрладаг. Булган аймгийн Орхон, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумдтай хиллэдэг.

Далайн түвшнээс дээш 1000-1100 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд Булган аймгийн зүүн урд Туулын дэд мужид багтдаг. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр буюу мал аж ахуй болон газар тариалан, аялал жуулчлал эрхлэхэд тохиромжтой. Газар хөдлөлийн эрчим 9 балл байна.

Хуурайдуу сэрүүн зунтай, хүйтэн өвөлтэй, 1 дүгээр сарын дундаж температур – 17°C, 7 дугаар сарын дундаж температур + 16°C, жилийн дундаж салхины хурд 4-6 м/с, жилийн хур тунадасны нийлбэр 300-400 мм хүрдэг.

2.2. Нийгэм эдийн засаг

Булган аймгийн Бүрэгхангай сум нь 1923 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Сазан Бүрэг уулын хошуу. Бумбат, Цахт, Дэрст, Дархан гэсэн 4 багийн нийт 782 өрхөд 2560 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Булган аймгийн 16 сумаас эхнээсээ 13-д, газар нутгийн хэмжээгээр 5-д жагсдаг байна.

Мал аж ахуй: Сумын хэмжээгээр нийт цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 52.1 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 21.7 хувь байна. 420 малчин өрх, 97 мал бүхий өрх байгаа нь сумын нийт өрхийн 66.1 хувийг эзэлж байна.

Сумын хэмжээнд 240103 толгой малтайгаас 270 тэмээ, 14060 адуу, 15935 үхэр, 124192 хонь, 85646 ямаа байна.

Газар тариалан: Сумын хэмжээнд нийт 1614 га-д газар тариалан эрхэлдэг. Үүнээс 1.5 хувьд нь төмс, хүнсний ногоо, 53.9 хувьд нь улаанбуудай, 44.6 хувьд таримал тариалж байна. Сумын хэмжээгээр жилд 870 га талбайд үр тариа, 17 га талбайд төмс, 8 га талбайд хүнсний ногоо, 90 га талбайд тэжээлийн ургамал, тосны ургамал 605 га-д тариалж, 1200 тонн үр тариа, 190 тонн төмс, 96 тонн хүнсний ногоо, 125 тонн тэжээлийн ургамал хураан авч байна.

Цахилгаан хангамж: Сум нь Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 1985 онд баригдсан 35/10 квт-ын дэд станц, 2013 онд баригдсан 10/04-ын станцтай.

Зам тээвэр: Сумын газар нутгаас Туулын гүүр ортол 40 км яваад УБ ордог хатуу хучилттай замтай холбогддог. Багууд хоорондоо шороон замаар холбогддог.

Ус хангамж: Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 5 худаг байна. Эрүүл мэндийн төв тусдаа гүний худагтай, бусад ААН байгууллага, айл өрхүүд гүний худгаас болон зөөврийн морин тэрэгнээс усаа авч байна.



3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Агаарын чанар

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Хүдэр боловсруулах үед үүсэх тоосжилт
- Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Машин техникийг тогтмол үзлэгт хамрагдуулж байх, янданд шүүлтүүр тавих
- Зам талбайг тогтмол усалж чийгшүүлж байх
- Ажилчдын амрах байр сууцны гадна талбайг зүлэгжүүлж тохижуулж агаарын чанарыг сайжруулах
- Хог хаягдлыг цаг тухай бүрд ачуулж, ангилах ялгаж байх
- Төсөл хэрэгжих бүхий хугацаанд агаарын тоос болон хорт бодисыг хэмжилтийн цэг бүр дээр тогтмол хийж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм

3.2. Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- Олон салаа зам гарган зорчих
- Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- Олон салаа зам гаргахгүй байх, зам талбайн тэмдэгжүүлэлт хийх
- Уурхайн гадаад болон дотоод тээврийн замыг хатуу хучилттай болгох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаях, цаг тухай бүрд ачуулах, ангилан ялгаж байх



- Цэвэрлэх байгууламж болон ариун цэврийн байгууламжийг байгаль ээлтэй технологийг сонгон ашиглах эдгээрийн эвдрэл гэмтлийг шалгаж байх
- Уурхайн машин техник төхөөрөмжийн үзлэг шинжилгээг тогтмол хийж байх

3.3. Гадаргын болон газрын доорх ус

Өндөр-Эрэг 2 алтны шороон орд нь гидрогеологийн мужлалаар улирлын дунд зэрэг тэжээгдэлтэй их муж, Монгол төв хэсгийн дэд мужийн Туулын дүүрэгт хамаардаг байна. /Н.Жадамбаа нар МГАМ боть VIII/

Хойт мөсөн далайн ай савд хамаарах Туул голын сав газарт хамаарна. Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд тархсан хурдас чулуулгийн гарал үүсэл, литологийн бүрэлдэхүүнийг үндэслэн газар доорх усны төрлүүдийг ялгаж, гидрогеологийн нөхцлийг тодорхойлохдоо талбайн хэмжээнд болон зэргэлдээх талбайд өмнө тэмдэглэгдсэн уст цэгүүдийн судалгааны материалууд дээр тулгуурлан бие даасан устай үе, давхрага, ан цавын уст бүрдлүүдийг ялгаж, ус агуулагч үндсэн хурдас чулуулгуудын гарал үүсэл, насаар нь дараах байдлаар давхарга зүйн ангилал хийсэн байна. Үүнд:

1. Кайнозойн сэвсгэр хурдас дахь уст давхарга;
2. Дунд кембри-Доод ордовикийн хурдас дахь уст давхарга;

Кайнозойн сэвсгэр хурдас дахь уст давхарга: Уст давхарга нь ихэвчлэн элс, дайрганы сул үеүүдэд газар доорх ус нь чөлөөт ба түрэлтэт гадаргуугийн хэлбэртэй оршино. Энэхүү уст давхарга нь хуурай сайр, жалга хөндийнүүдэд ихэвчлэн аллюви-пролюви, пролювийн гаралтай, элсэрхэг, шаварлаг хурдас, үндсэн чулуулгийн хайрга, дайрга зарим тохиолдолд муу мөлгөржсөн хэмхдэслэг хурдаст оршино. Аллюви-пролювийн, пролювийн хурдасны зузаан хэдэн 10 м хүрдэг байна.

Терриген тунамал-хувирмал чулуулгийн уст бүрдэл: Тусгай зөвшөөрлийн талбай орчимд дунд кембри-доод ордовикийн Хараа серийн Заамар, Доргонт формацийн ногоон саарал өнгийн занаржсан элсжин, шохойлог элсжин, алевролит, мета элсжин, метаалевролит, төрөл бүрийн найрлагатай занар зэрэг чулуулгууд агуулагдана. Дунд кембри-доод ордовикийн настай хувирмал чулуулгууд нь ан цавшилд нилээд идэвхтэй автсан боловч, ан цавшил нь талбайн тархалт болон босоо зүсэлтийн дагуу жигд бус учраас хэсэгчилсэн талбайд газар доорх усны хязгаарлагдмал хуримтлал, бөөгнөрлийг үүсгэх байгалийн нөхцлийг бий болгодог бөгөөд энэхүү хуримтлал бөөгнөрөл нь улирлын шууд нөлөөлөл дор байдаг. Иймд энэ төрлийн газар доорх ус нь нөөц ихтэй, өгөршлийн ан цавын сүлжээнд агуулагдаж байхдаа биеэ даасан уст үе давхаргыг үүсгэдэг онцлогтой.

Өндөр-Эрэг 2 ордын гидрогеологийн хувьд 2020 онд хайгуулын ажлын үр дүнгээр хайгуулын цооног, шурфэнд ус гараагүй, цэвдэг, намагшил үгүй, хуурай учир ашиглалтын үед хүндрэл учрахгүй бөгөөд гидрогеологийн нөхцөлийн хувьд Туул голын талд 1.5 км-т орших Тосонгийн дэнж, жалгын ордынхтой адилтгаж үзжээ. Усан хангамжийг ордоос хамгийн ойр орших Туул голоос /350 м-ээс/ шийдвэрлэх боломжтой.



3.4. Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Ажиллагсдын ихэнх нь дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй нөхцөлд ажиллахаар байгаа тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөх магадлалтай юм. Түүнчлэн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх магадлалтай байна. Байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хугацаанд хамрагдуулж байх
- Эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өдөр бүр өгч байх
- Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон зориулалтын ажлын хувцсаар хангах
- Галын аюулгүй ажиллагаа болон гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах
- Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин мөрдүүлэх тал дээр хяналт тавих

3.5. Ургамлан нөмрөг

Хүнд машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч алдагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- Амрах байрнаас хоолны газар хүрэх зам гэх мэт явган хүний замыг нэг маршрутаар болгож цементлэн хашиж аль болох унаган ургамлыг нь гэмтээхгүй байх
- Гадна талбайг тохижуулах хашиж хамгаалах, тогтмол усалж арчилж байх
- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын зэрэг барилга байгууламжид галын аюулгүй ажиллагааны буланг хийх ажилчдад хэрэглэх заавар зөвлөгөө санамжийг тогтмол өгөх, сургалт зохион байгуулах

3.6. Амьтны аймаг

Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төсөл хэрэгжих газар тээврийн хэрэгсэл, хүний хөдөлгөөн ихсэж, дуу чимээний нөлөөлөл зэргээс жижиг амьтад дайжих, амьдрах орчин хумигдсан. Харин ногоон байгууламжийг байгуулснаар төслийн ойр орчмын талбайд тархах зарим амьтдад амьдрахад эерэг нөлөөлөл үзүүлж болох юм.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ



- Хөрсийг зүй зохистой ашиглах, олон салаа зам гаргахгүй байх, тогтсон нэг замаар тээврийн хэрэгслүүдийг зорчуулах.
- Ховор амьтдыг устахаас хамгаалж өөр газар шилжүүлэх болон биотехникийн арга хэмжээ авах талаар судалгаа хийх, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгуулахын зөвлөмж авч хэрэгжүүлэх
- Уулын малталт, овоолгыг ан амьтанд аюулгүй байхаар байрлуулах
- Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах

3.7. Нийгэм эдийн засаг

Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага ба аливаа болзошгүй нөлөөлөл нь хүний анхаарал, болгоомжгүй, хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаална.

Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.



4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээсэн.

Иймд 2023 онд мэргэжлийн эрх бүхий “Теем смайл” ХХК-иар боловсруулсан менежментийн төлөвлөгөөний дагуу 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29- ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хянан батлах журмыг баримтлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2024 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 7,948,000 төг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хэрэгжүүлсэн арга хэмжээ		Нийт зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,400,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	3,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	100,000
6	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,000,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	648,000
8	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
Нийт		7,148,000



4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал	
Агаар орчин	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Тээврийн зам, уурхайн аманд тоосжилт их буй газруудад	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	<ul style="list-style-type: none"> MNS5885:2008 MNS(ISO)13688:2000 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004 	
	Уурхайн карьерт орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай ялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах		-	-	-				
	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийж агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Тээврийн хэрэгслүүдэд	-	-	-				
	Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх засвар үйлчилгээг тогтмол хийх		-	-	-				
	Уурхайн ажиллагсад тоосноос хамгаалах хошуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах сургалт явуулах	Уурхайн ажилчид	-	-	-				
Гадаргын болон газрын доорх ус	Ус ашиглалтын гэрээ байгуулах	Төслийн хэмжээнд	-	-	-	-	2-3 сард	<ul style="list-style-type: none"> Усны тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль 	
	Ус ашигласны төлбөр төлөх		-	-	-	-	12 сард		
	Худгын барилга, байгууламж байгуулах	Худаг 1, 2	ширхэг	6,000.0	2	1,200.0	2-р улиралд		
Хөрсөн бүрхэвч	Уурхайн орчны замыг стандартын дагуу тавих, тэмдэгжүүлэх ажил хийх олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	ширхэг	200.0	4	800.0	2-р улиралд	<ul style="list-style-type: none"> Газрын тухай хууль MNS4597:2014 MNS4759:2014 	
	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах		тогтмол	ХАБЭА ажилтан харицан гүйцэтгэнэ.					Үйл ажиллагааны турш.
	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтад хяналт тавих		тогтмол						
	Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	-	-	-	-	Тогтмол хэрэгжинэ			



Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
	Хөрсөнд нэвчилтгүй ариун цэврийн байгууламж суурилуулах		ш	5,000.0	1	5,000.0 /Үйл ажиллагааны зардлаар гүйцэтгэнэ/	2-р улиралд багтаан	
	Ариун цэврийн байгууламжинд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх		удаа	100.0	4	400.0	2 сард 1 удаа	
	Шаардлагагүй газар ухаж сэндийчихгүй байх.		тогтмол	Ашиглалтын инженер			Тогтмол хэрэгжинэ.	
Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний зардал						2,400,000		

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Тус онд ордын уул техникийн нөхцөлөөс хамаарч 2023 онд олборлолт явуулсан В-1 блокийн ашиглалтыг дуусган 4.0 га талбайд В-2, В-3 блокын хөрсөөр дотоод овоолго хийгдэнэ. Ашиглалтын хугацаанаас хамааран биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй байна.

4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	Булгийн эх хашиж хамгаалах	Орон нутгаас өгсөн саналын дагуу булгын эхийг хашин тэмдэгжүүлэн хамгаална.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	1 булаг	Хашаа худалдан авах байгууллагын гэрээний дүнгээр хийж гүйцэтгэнэ.		05-10 сар	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
2	Эзэнгүй орхигдсон талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Бүрэгхангай сумын байгаль орчны байцаагчын зааж өгсөн 5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэнэ.		5.0 га	Өөрсдийн тоног төхөөрөмжөөр гүйцэтгэнэ.			
3	Тэрбум мод хөдөлгөөны хүрээнд	500 ширхэг мод тариалах		500	3,000.0		Хавар, Намар	
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал					3,000,000			



4.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайд 3 байршилд хиргисүүр байрлаж байна. Тус хиргисүүр нь уурхайн олборлолтын талбайд өртөхгүй боловч ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байрлаж байгаа тул хашаалан, тэмдэгжүүлэх ажлыг тус онд гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал	Хашаалах	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд	3	Дотоод зардлаар		2-р улиралд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
1	Ажилчид гэмтэж бэртэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн багаж хэрэгсэл байршуулах	Ажилчдын эрүүл мэнд	- 1	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан. 100.0	Төслийн хугацаанд Төсөл хэрэгжихээс өмнө	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага	
2	Гэнэтийн үер усны аюул	Гэнэтийн осолын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Үйлдвэрийн үйл ажиллагаа, ажилчдын эрүүл мэнд	-	ХАБ-ын мэргэжилтэн	Төсөл хэрэгжихээс өмнө	MNS AASHTO M 86 : 2005 Бетонон суваг, үерийн ус зайлуулах хоолой Техникийн шаардлага	
3	Гал түймэр гарах	Төслийн талбайд болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гал унтраах хэрэгсэдийн хугацаа, ажиллагаанд хяналт тавьж шалгах	Уурхайн үйл ажиллагаа, ажилчдын эрүүл мэнд	1 ш	ХАБ, дотоод хяналтын ажилтан хяналт тавина.	Тогтмол	Галын аюулгүй байдлын тухай хууль Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм MNS 6576:2016	



							Гал түймэртэй тэмцэх. Гал түймэр унтраах даралтын хоолой. Техникийн шаардлага
4	Ажилчдын хайхрамжгүй үйлдлээс болж осол гарах	Ажилчдад ХАБЭА ажилтан өдөр тутамд аюулгүй ажиллагааны сургалт мэдээлэл өгч ажиллах	Ажилчдын эрүүл мэнд	Өдөр бүр	ХАБ-ын мэргэжилтэн сургалт орох	Өдөр бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал					100,000		

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8
Ахуйн хог хаягдал	Хатуу хог хаягдлын түр цэг байгуулах	Хог хаягдлын менежмент	1 ш/удаа	500.0	500.0	7 сард	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003 БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам” Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар 10.2.3, 10.2.4
	Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зайлуулах гэрээг Бүрэгхангай сумын ТҮГ-тай байгуулж сумын нэгдсэн хогийн цэгт тогтмол зөөвөрлөн зайлуулах	Хог хаягдлын менежмент	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Хог хаягдлыг ангилах	Кемпийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		Тогтмол	
Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлын талбай, байр байгуулан бүртгэлжүүлэн ажиллах	Хадгалагдсан баттерей, аккумулятор, тосны шүүр, тосны хаягдал	1 ш	500.0	500.0	7 сард	“Хог хаягдлын тухай хууль” БОАЖС-ын 2018 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах



БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ӨНДӨР ЭРЭГ-II” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
							шаардлага болон зөвшөөрөл олгох журам
Хог хаягдлын менежментийн зардал						1,000,000	



4.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Тайлбар	Баримтлах стандарт
	1	2	3	4	5	6	7	8
УСАН ОРЧНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								
1	~ Усны физик шинж чанар, ерөнхий химийн найрлага, шим бохирдуулагчийн үзүүлэлтүүдийн шинжилгээ, микробиологийн шинжилгээ ~ Хаягдлын сан дээр усны хүнд металлын шинжилгээ хийх	мг/дм ³ 1 мл-т илрүүлэх 100 мл-т	Туул гол Ундны ус Цэвэр нуур Нийт 3 цэгт	Жилд 2 удаа	47.5	95.0	Булган аймгийн ЦУОШГ-аар гүйцэтгүүлнэ.	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 0900:2018 Ундны усны стандарт
ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								
2.	~ Хөрсний физик, химийн шинж чанар ~ Хөрсний хүнд металлын агууламж ~ Эрүүл ахуй	мг/кг	Уурхайн ам Кемпийн талбай Эрүүл талбай Нийт 3 цэгт	Жилд 2 удаа	115.0	345.0	Булган аймгийн ЦУОШГ-аар гүйцэтгүүлнэ.	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт
АГААР ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								
3.	~ Азотын давхар исэл (NOX) ~ Хүхэрлэг хий (SO2) ~ Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO2) ~ Агаарын тоос тоосонцор (PM2.5, PM10) ~ Дуу чимээ	мкг/м ³ дБА	Уурхайн ам Уурхайн тосгон Дотоод зам Нийт 3 цэгт	Жилд 2 удаа	65.0	208.0	Булган аймгийн ЦУОШГ-аар гүйцэтгүүлнэ.	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
Орчны хяналт, шинжилгээний зардал						648,000		



4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан
		2024 он				
		I-улирал	II-улирал	III-улирал	IV-улирал	
Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн журам гарган ажилчдад мөрдүүлэн ажиллах.	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	+	Удирдах албан тушаалтан
Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах		+		+		
Байгаль орчны аудит хийлгэх	Гэрээний дүнгээр	-	-	+	-	
Байгаль орчны жил бүрийн төлөвлөгөөг байгаль орчны ямаар батлуулж мөрдөн ажиллах	-	+	-	-	+	



ДҮГНЭЛТ

“Хантэнгэрийн дуудлага” ХХК нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт “Өндөр эрэг-II” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийг 2023 оны 09 дугаар сараас 11 сар хүртэл олборлолтын үйл ажиллагааг явуулсан бөгөөд 2024 онд 04 сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөөд байна.

Төслийн хүрээнд 2024 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд **7,148,000 төгрөг** ба үүнд 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, дүйцүүлэн хамгааллын ажлын зардлууд багтсан болно.



Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршуулсан баримт

ГОЛОМТ БАНК
Сайн сайсныг санхүүжүүлнэ

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 237510170

Татсан огноо: 2024-02-06 16:44

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
3635177813 MN430015003635177813	100900013406	3,574,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ХАН ТЭНГЭРИЙН ДУУДЛАГА	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга Хан тэнгэрийн дуудлага РД:5287359 2024 БОМТ барьцаа	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2024-02-06	

Гүйлгээг шивсэн хэрэглэгч
д. дашчойнхор

Гүйлгээг хянасан хэрэглэгч

Гүйлгээг баталсан хэрэглэгч

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

ГОЛОМТ БАНК
Сайн сайсныг санхүүжүүлнэ

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 251788722

Татсан огноо: 2024-04-17 15:01

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
3635177813 MN430015003635177813	100900013406	11,901,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ХАН ТЭНГЭРИЙН ДУУДЛАГА	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга 5287359-Хантэнгэрийн дуудлага ХХК 2024 БОМТ барьцаа төлбөр	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2024-04-17	

Гүйлгээг шивсэн хэрэглэгч
д. дашчойнхор

Гүйлгээг хянасан хэрэглэгч

Гүйлгээг баталсан хэрэглэгч

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.